



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 05 сарын 19 өдөр

Дугаар 271

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 125 дугаар тогтоол, “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТӨГТООХ нь:

1.Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын төсвийн багцын улсын төсвийн эрх шилжүүлсэн хөрөнгө оруулалтаар бий болсон, хавсралтад заасан Дорноговь аймаг дахь “Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад, эмэгтэйчүүдийн хөгжлийн төв”-ийн барилгыг төрийн өмчид бүртгэж, Дорноговь аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт эзэмшигүүлсүгэй.

2.Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Өнөрбаяр, Дорноговь аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга Д.Цэндмаа нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Комисс томилон хөрөнгө хүлээн авч, бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА


3.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.Нарангэрэл

000201

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн
27/ дугаар тогтоолын хавсралт



Дорноговь аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний
газрын үндсэн хөрөнгөд бүртгэх барилга

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон он	Балансын үнэ (төгрөг)	Байршил	Талбайн хэмжээ м.кв
1	“Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад, эмэгтэйчүүдийн хөгжлийн төв”-ийн барилга	2018	2,900,000,000.00	Сайншанд сумын 2-р баг	564м2 зоорийн давхарын хамт 4 давхар
	Дүн		2,900,000,000.00 <i>/хоёр тэрбум есөн зуун сая/</i>		